

Сүүлийн үед Францаас олдсоор буй
монгол судлалын зарим
эх хэрэглэгдэхүүний тухай

Ц. Шагдарсүрэн (МУИС)

Европын улс орны дотроос дундад зууны үед Монголыг ажин анхаарч, хамтран эвсэж байсан хамгийн анхны улс орон бол Франц байсан гэдэгийг өдгөө Парис хотноо уг эхээрээ хадгалагдаж буй Гоо Филиппэд илгээсэн хоёр монгол захиа гэрчилнэ. 1289 оны Ил хан Аргуны захидалд цэрэг дайны явдал гарч байсан бол арав гаруйхан жилийн дараахи 1305 оны Өлзийт ханы захидалд огт өөр асуудал, тухайлбал: дэлхий нийтийн энх тайвангийн санаа тусгалаа олсон гэж олон эрдэмтэд үздэг билээ¹. Энэ бол улс төр, дипломатын салбарт холбогдох зүйл.

Үүний хажуугаар монгол хэл, монгол бичиг үсгийн талаар европ тивд нийтлэгдсэн анхны хэлзүйн бичиг, судлагааны томоохон бүтээлүүд мөн л Францад гарсан болоод франц эрдэмтэдэд хамаарч байна². Энэ бол монгол хэл, монгол үсэг бичигийн салбарт холбогдох зүйл.

¹ W. Kotwicz, *Les Mongols, promoteur de l'idée de paix universelle au debut du XIIIe siècle*, - *Rocznik Orientalistyczny*, Tom. XVI [1950], Krakow, 1953 - Монгол орчуулга нь: Хэл зохиол судлал, IX боть, 20-р дэвтэр, Улаанбаатар, 1974, 205 - 214 х; Grzegorz Leopold Seidler, *The political doctrine of the Mongols*, - *Annales Universitatis Marie-Curie Sklodowska*, Lublin, Polonia, Vol. VI.7, 1959, pp. 249- 277; Mostaert A, Cleaves F. W, *Les lettres de 1289 et 1305 des Ilkhans Argun et Öljeitu à Philippe le Bel*, Cambridge, 1962; Chantal Lemerrier-Quellejay, *La paix mongole, Joug tatar ou paix mongol?* Paris, 1970.

² Melchisedek Thevenot, *L'essai de la grammaire mongole*, Paris, 1672 [Pentti Aalto, *L'esquisse de la Grammaire mongole qu'on trouve chez Melchisedech Thévenot*, - CAJ, Tom. VIII, 1963, pp. 151-162]; Abel Remusat, *Recherches sur les langues Tartares ou memoires*, Paris, 1820; Leon Feer, *Tableau de la Grammaire mongole, suivi de l'Elevation de Gengis khan et de la Lettre d'Arghoun khan à Philippe le Bel*, Paris [Rue Monsieur le Prince 25], 1866, 10 p; Le Baron Vitale, Le Comte de Sercey, *Grammaire & Vocabulaire de la Langue Mongole* (Dialecte des Khalkhas), Peking, 1897; E. Blochet, *Les inscriptions turques de l'Orkhon*, - *Revue Archeologique*, Troisieme serie, XXXII, mai-juin 1898, Paris; P. Pelliot, *Les systèmes d'écriture en usage chez les anciens mongols*, AM, 2 (2), Leipzig, 1925, pp. 284-289; P. Pelliot, *Les mots à H - initiale aujourd'hui amuie dans le mongol des XIIIe et XIVE siècles*, - JA, April-June, 1925, pp. 1-47.

Дээр дурдсан салбараар харьцангуй эрт гарсан бүтээлийг манайхин тэр бүр сайн мэддэггүй байдал харагдах боловч харин Монголын түүх, соёлын талаар M. Quatremère, E. Blochet, P. Pelliot, René Grousset, R. Bonaparte зэрэг түүх үеийн нэрт түүхч эрдэмтдийн өдий төдий ном зохиол, цомог гарсаныг бид нэлээд сайн мэдэх билээ³.

Монголыг судласан P. Pelliot, E. Blochet зэрэг олон франц эрдэмтэн анх нангиадын судлалаар ажиллаж байгаад эрдэм шинжилгээний ажлын шаардалгаар монголын судлал руу арга буюу орж дэлхийд нэр хүндтэй олон монголч эрдэмтний эгнээг өргөтгөсөн гэдэгийг дурдалгүй орхих аргагүй. Үүнийг дурдахын учир гэвэл, тэд нар хятадад ажиллах хугацаандаа монголын судлалд холбогдох хэрэглэгдэхүүнд анхаарч ирсэн нь бидний хувьд онцгой завшаантай хэрэг болсон гэдэгийг тэмдэглэх гэсэн зорилготой холбоотой юм.

Энэ бүхний дүнд монголын судлалд шууд холбогдох бичиг баримт, дурасхалын зүйлс францын номын сан хөмрөгүүдэд хадгалагдаж ирсэн нь шинээр гарч ирсээр байна. Энэхүү тэмдэглэлд сүүлийн үед тийнхүү олдсон гурван дурсгалын талаар товч танилцуулахыг зорилоо.

1. Францын Улсын Номын сан [*Bibliothèque nationale de France* (58 rue de Richelieu)]-гийн Дорно дахины хөмрөгт 124 гэдэг дугаар бүхий тод номын барын нэг мод хадгалагдаж байгааг 2002 оны зун Францын Монгол судлалын төвд ажиллах хугацаандаа уг төв болон францын CNRS-ын ЭШ-ний ажилтан, монголч эрдэмтэн Марие-Доминик Эвэн (Marie-Dominique Even)-ий тусламжаар олж үзэн гэрэл зурагийн хуулбары нь олж авсан билээ. Уг хадгаламжийн товъёгт:

N. 124: Planche de bois gravée pour l'impression d'un traité bouddhique qui paraît être la traduction en langue kalmouke by Vadjaratchedika, feuillet 14. Il ya est parlé de Soubhouti comme interlocuteur de Bouddha. (247 x 78 mm). (Ancien tibetain-mongol 129)

хэмээн бичижхүй (1-р зураг). Үүнээс үзэхүл монголчуудын дунд "Доржзодов" гэдэг, баруун монголчуудын дунд "Хутагт билигийн чинад хүрсэн таслагч очир хэмээх их хөлгөний судар" (*Vadjaratchedika / Vajrachedikā*) хэмээн машид дэлгэрсэн ном болох нь мэдэгдэх бөгөөд энэхүү бар модын нэг (recto ? verso ?) талд *arban dörbön* хэмээн хуудасны дугаарыг сийлжээ. Бар модын байдалыг гүйлгэн авч үзвэл: зарим хэсэг нь эмтэрсэн, бичвэрийн хувьд аман ярианы хэлбэр давамгайлсан, *i* эгшиг нь монгол бичигийн хэлбэрт илүү ойрхон байдал давын өмнө харагдана.

Бар модын хэмжээ: 248 мм x 78 мм x 25 мм;
Бичвэрийн талбай: 190 мм x 58 мм;
Мөрийн тоо: recto (?): 1 (хуудасны дугаар) + 13
verso (?): 13.

³ Abel Rémusat, *Mémoires sur les relations des Princes Chétiens avec les Empereurs mongols*, Paris, 1824; M. Quatremère, *Histoire des Mongols de la Perse*, I, Paris, 1836; Bonaparte R, *Documents de l'époque mongole des XIIe et XIIIe siècles*, Paris, 1895; E. Blochet, *Introduction à l'histoire des Mongols de Fadh Allah Rashid ed-Din*, GSM, Vol. XII, 1910; René Grousset, *L'Empire mongol*, De Boccard, 1940; René Grousset, *Le Conquérant du monde: Gengis Khan*, Albin Michel, 1944, René Grousset, *L'Empire des steppes*, Payot, 1952.

Харамсалтай нь энэхүү бар модыг анх хэн, хэдийд, хаанаас олж Францын Улсын номын сангийн хөмрөгт оруулсан тухай баримт үгүй байна. Харин уг хадгаламжийн талаар Номын сангаас 1973 онд гаргасан үзэсгэлэнгийн танилцуулгад товч дурдсан зүйл буйг эшлэн танилцуулбал:

Les mongols, ... 285. Planche de bois gravée en sens inverse, destinée à l'impression d'un feuillet du Vajracchedikā, traité bouddhique. - Mongol, 18^e siècle. 250X 80 mm. B.N., Mss., mongol 124...

гэсэн байна⁴.

Тод бичигээр бидний үед золгон ирсэн ном сударыг үзэхэд их төлөв гарбичмэл байдаг бөгөөд нэгэн хэсэгтээ судлагчдын дунд тод бичигийн барын ном байдаггүй гэдэг дүгнэлт ч гарч байлаа. Гэвч сүүлийн үед олдсон тод барын номын дурасхал болон яргуулан үзсэн судлагааны дүнд тод барын ном байсан гэдэг нь нэгэнт нутлагдсан билээ. Одоо бидний мэдэхийн хэрээр лавтайяа, их бага хэмжээний 12 ном, нэг тарни, нэг номын хөнжил, нийт 14 зүйлийн бар байжээ. Хамгийн том барын номоос дурдвал: 382 хуудастай "Хутагт билигийн чинад хүрсэн найман мянгат" (427 мм х 109 мм), 120, 92 хуудас бүхий хоёр янзын "Хутагт сударын аймагийн эрхэт Алтангэрэл хэмээх их хөлгөний судар" (380 мм х 86 мм; 440 мм х 127 мм), 69 хуудас "Аршааны зүрхэн найман үет нууц увидасын үндүсэнээс дөтгөөр хэсэг хойт үндүсэн" (535 мм х 110 мм) зэрэг болно. Тод барын номын дотор "Хутагт билигийн чинад хүрсэн таслагч очир хэмээх их хөлгөний судар" гурван зүйл байх бөгөөд цөм өөр өөр барынхи ажээ. Үүнд: нэг нь, 55 хуудастай (192 мм х 49 мм), нөгөө нь 56 хуудастай (195 мм х 45 мм), гуравдахи нь 56 хуудас бүхий (335 мм х 130 мм)⁵.

Эрдэмтэн Х. Лувсанбалданы судлагаанаас үзвэл нэг ном 2-3 удаа бард гарч байсаны баримт тодорхой харагдаж байна. Бидний гол судлагдахуун болж буй Парисаас олдсон "Хутагт билигийн чинад хүрсэн таслагч очир хэмээх их хөлгөний судар"-ын ганц бар модны хэмжээ дамжаа нь одоо бидний мэдэж буй гурван зүйл барын "Хутагт билигийн чинад хүрсэн таслагч очир хэмээх их хөлгөний судар"-аас өөр байгаа тул наад зах нь эл сударыг дөрвөнтөө барласан байна гэдэг анхны дүгнэлт хийх боломжийг олгож байна.

Түрүү түрүүчийн судлагаанаас үзэхэд бие бодтой үлдсэн тод бичигийн бар мод гэвэл тарни сийлсэн нэг бар мод Увс аймагийн Орон нутагийг судлах музейд хадгалагдаж байгаа гэдэг мэдээтэй тул Францад хадгалагдаж буй энэхүү ганц бар мод нь одоогийн байдалаар тод бичигийн бар гэдэг талаасаа хоёрдахи, судар номын барын тухайд цорын ганц дурасхал болох тул эрдэм шинжилгээний үүднээс үнэт ховор хэрэглэгдэхүүн болж байна. Энэ дурасхалын талаар Марие-Доминик Эвэний хамт тусхай нэгэн өгүүлэл бичихээр төлөвлөж байна.

⁴ *Trésors d'Orient*, Bibliothèque National (Exposition), Paris, 1973, 196 p: Cf. pp. 107-112.

⁵ Х. Лувсанбалдан, *Тод үсэг түүний дурсгалууд*. Улаанбаатар, 1975, 112-122.

2. Франц Улсын Номын санд хадгалагдаж байсан тодруулга зураг бүхий монгол бичигээрхи хуйлмал дурасхалыг францын залуу монголч эрдэмтэн Лаказ Гайэл (Gaëlle Lakaze), хятадач-монголч Изабел Шарлө (Isabelle Charleux) нар хэлний онцлог болон түүхэн үйл явдалын талаас нь судлаж байна (2, 3-р зураг).

Уг дурасхалыг хэн, хаанаас, хэзээ олж номын сангийн хөмрөгт оруулсан тухай мэдээ занги энэ хэр байхгүй байгаа ажээ. Энэхүү хуйлмал дурасхалыг тодорхой түүхэн үйл явдалын тэмдэглэл-баримт, монгол бичигийн хэлний дурасхал, чимэг зурагийн хамт урлагийн бүтээл гэж үзэх бүрэн үндэстэй юм. Агуулга нь гэвэл: Сайшаалт Ерөөлтийн арвангуравдугаар он (1808)-ы зуны тэргүүн сард Манжийн төрийн зүгээс IX Далай лам Лүндогжамц (1805-1815)-ыг ширээнд залах албан ёсны ёслолоор эхлэж, арвандөрөвдүгээр оны намарын тэргүүн сар хүртэлхи нэг жил илүүгийн хугацаанд Далай ламтаны гүйцэтгэсэн үйл ажиллагаа, аялал тэргүүтэнийг багтааж нийслэл хотноо эгэн ирэх хүртэлхи үйл явдалыг нь тэмдэглэсэн ажээ.

Монгол бичигээр буй энэхүү албан ёсны тэмдэглэл нь нэлээд том, 118 мөр бичигтэй, ширээнд залах үеийн байдалыг өнгө ялгаж, хэн хаана сууж байсан зэргийг тодруулан тэмдэглэсэн төдийгүй аян замын гудас дахи учрал тохиол зэргийг харуулсан зураг бүхий хуйлмал дурасхал болно. Уг дурасхал чухам ямар хэмжээ дамжаатай болох хийгээд агуулга, зураг тэргүүтэний нарийн учир холбогдолыг тодруулан гаргах нь тухайлан судлаж байгаа хоёр залуу эрдэмтэн бүсгүйн хэрэг тул ийнхүү товчлов.

Харин уг албан ёсны тэмдэглэлийг юуны учир манж буюу хятадаад бус, монгол хэлээр, монгол бичигээр хөтлөв? гэдэг нь бидний сонирхолыг зүй ёсоор татаж байна. Яг үүнлүгээ адил сонирхол татаж байсан, нэлээд түрүү үеийн өөр баримт ч буй билээ. Тухайлбал: 1640 онд Манжийн төрийн зүгээс Солонгосыг орж өгсөний нутлагаа болгож Сөүл хотноо босгосон Samjōn-do (Samchōndo)-гийн гурван хэлний бичээст хөшөөний нүүрэн талд нь манж, монголоор, ар талд нь хятадаар бичсэн байдаг юм⁶. Энэ бүхэнээс үзвэл, Манжийн төрийн бодолгод

⁶ W. B. Carles, *A Korean Monument to Manchu Clemency*. - Journal of the North China Branch of the Royal Asiatic Society for the 1888. New Series, Vol. 23, 1889, pp. [1]-8 and 285, + plate; А. Позднеев, *Каменописный памятник подчинения Маньчжурами Корея*, - Записки Восточного Отделения Императорского Русского Археологического Общества, Том. V, Выпуск 1, С- Петербург, 1890, стр. 37 - 55; *Поправка о статье "Каменописный памятник подчинения Маньчжурами Корея"* - Записки Восточного Отделения Императорского Русского Археологического Общества, Том. V11, 1892|1892, С- Петербург, стр. 326 - 327; Berthold Laufer, *Skizze der mongolische Literatur*, - Keleti Szemle Revue Orientale, Tome VIII, Kötet, Budapest, 1907, pp. [165]-261; Walter Fuch, *Early Manchurian Inscription in Manchuria*. - The China Journal, vol. XV, No. 1, July 1931, pp. 5-9 + 3 plates, p. 7; Louis Hambis, *Grammaire de la langue mongole écrite*. Premiere partie. Paris, 1946, p. 97. (21: Monument de la soumission de la Coree aux Mandchous.) Louis Ligeti, *Deux tablettes de T'ai-tsong des Ts'ing*. - Acta Orientalia Hung., Tomus VIII, Fasc. 3, Budapest, 1958, pp. [201] - 239; H Walravens, *Übersicht über chinesische Steinabklatsche mit mandjunschen Inschriften in amerikanischer Sammlungen*. - Tractata Altaica, Wiesbaden, 1976, pp. 743-753; Samuel M. Grupper, *A Handlist of Manchu Epigraphical Monuments*: 1. The Reigns of T'ai-tsong and Shun-chih Emperor, Manchu Studies Newsletter, Issue 1, Issue 2, 1977, 1978, pp. 75-90; Francis Woodman Cleaves, *The Mongolian Text of the Tri-lingual Inscription of 1640 (part I)*, - Mongolian Studies, Vol. XVIII, Bloomington, 1995, pp. 3 - 47; (part II: Notes to the Translation) : Vol. XIX, Bloomington, 1996, pp. 3 - 49; Б. Сумъяабаатар, *Гурван Ханы нутаг дахь Гэрэлт хөшөөний*

монгол бичиг тодорхой хэмжээгээр зохих байр суурьтай байсаны гэрч буй заа гэж үзэх үндэслэл гарч болзошгүй юм.

3. Юан гүрэний үеийн төрийн бичиг болж байсан монгол дөрвөлжин бичигээрхи тамга, тэмдэгийн зүйл сүүлийн үед шил шилээ даран гарч ирсээр байна. Нэлээд хэдэн жилийн өмнө Японы эрэгт далайн шуурганд сөнөсөн усан онгоцноос нэг ийм тамга гарч олны анхааралыг татаж билээ. Бас Хятадын олон муж, түүний дотор Төвөдөөс монгол дөрвөлжин бичиг бүхий тамга тэмдэг олон олдсоныг эрдэмтэн Зуунаст авгай цувуулан судлаж гаргасаар байна. Гуравдахи мянган жил шилжирэн гарсаны эхний онд Хархориноос бас ийм нэгэн тамга гарсаныг Монголын эрдэмтэн Б. Сумъяабаатар⁷, Германы эрдэмтэн Eva Nagel⁸ нар тусхайлан судласан билээ.

2002 онд Францад Монголын судлалын төвөд ажиллах үедээ 1997 онд Парис хотноо хэвлэгдсэн "Хятадын сонгодог яруу найрагийн цоморлиг" гэдэг номыг үзэж суутал их шүлэгч Ли Бай - Ли Бо (Li Bai - Li Bo)-гийн зурагийг хавсаргасан байх бөгөөд тэр зурагийн баруун дээд талд зураачийн гарын тэмдэг - тийз (Ex-libris)-ийг даржээ⁹. Тэрхүү тамга нь дээд талаасаа яльгүй танагдсан байх боловч ханз дуудалгаар нь хөөн сэргээхэд төдий л төвөгтэй биш. Тамгын бичээсийг монголын дөрвөлжин бичигээр, хятад хэлээр бичсэн байх тул бидний сонирхолыг зүй ёсоор татсан билээ (4--р зураг).

Үүнээс үзэхүл их шүлэгчийн тэрхүү зургийг Юан улсын үед буюу түүнээс хойш зурсан болох нь тодрох бөгөөд зураач нь монгол хүн байж болзошгүй, эс бөгөөс хятад хүн байлаа гэхэд Юаны үеийн зураач байсан буй заа гэх зэрэг эхбичиг судлалын үүднээс хэд хэдэн таамаглал дэвшүүлэх боломж олгож байна.

Энэхүү тамгын бичээсийн талаар дараа тусхайлсан судлагааны нэг өгүүлэл гаргана гэж бодож байгаагийн дээр монголчуудын бичиг үсэгт холбогдох шинэ тутам олдсон баримт дурасхал бүрийг цаг тухай бүр нь нэхэн үзэж яргуулан судладаг доктор Б. Сумъяабаатар ч зүгээр суухгүй гэдэгт итгэж байна.

Энэхүү тэмдэглэлд франц нутагаас олдсоор буй монгол судлалын баримт хэрэглэгдэхүүнээс давын өмнө олон нийтийн сонирхолыг татах буй заа гэсэн гурван дурасхалын талаар сорлон оруулав.

монгол бичээс III, - The 14th International Conference KOREA and MONGOLIA, Ulaanbaatar, 2001, pp. 9-18; Б. Сумъяабаатар, *Гурван Ханы нутаг дахь Гэрэлт хөшөөний монгол бичээс IV*, - Mongolian Studies (The Korean Association for Mongol Studies), No. 12, 2002, Seoul, pp. 21-33.

⁷ Марал овогт Б. Сумъяабаатар энэ тамгын талаар Олон Улсын Монголч эрдэмтний ҮШ их хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн бөгөөд тэрхүү илтгэлээ улам боловсруулан засч 2002 онд гаргасан томоохон бүтээлдээ оруулсан байна:


Б. Сумъяабаатар, *Чингисийн алтан ургийн Угийн бичиг ба Гэрийн үеийн бичмэл*, Улаанбаатар, 2002. 620-630-р тал.

⁸ Eva Nagel, *A Secretary's Seal of the Ministry of Revenue issued in April 1372*, - Qara Qorum-City (Mongolia) I, Preliminary report of the excavations 2000-2001, Bonn, 2002, pp. 53-74.

⁹ Maurice Coyaud, *Anthologie de la poesie chinoise classique* (Edition bilingue), Paris, 1997, (345 p) p. 235.



1-р зураг



3-р зураг



4-р зураг